

ГЛОБАЛЬЧЛАЛЫН НӨХЦӨЛ ДЭХ ҮНДЭСТНИЙ ТӨРИЙН СУДАЛГААНЫ

ОНОЛ-АРГА ЗҮЙН ҮНДЭС

М.Мөнхзул багш, докторант

ХААИС, БУС, Нийгмийн ухааны тэнхим

Түлхүүр үг: Глобальчлал, үндэсний ухамсар, үндэстний гүрэн, угсаатан, ард түмэн

Товч хураангуй: “Үндэстэн гүрэн” гэдэг ойлголт нь өөрийнхөө агуулга багтаамжаараа болон хэрэглэгдэх индексээрээ “ардчилал”, “иргэний нийгэм” ба “хүний эрх” зэрэг ойлголтуудаас дутахгүй. Үндэстний гүрний тухай шинжлэх ухааны товч тодорхойлолтыг гаргахынхаа өмнө тухайн ойлголтын үгийн сангийн үндсэн хэсгийг бүрдүүлэгч “үндэстэн” ба “гүрэн” гэсэн үгнүүдийг авч үзэхийг оролдлоо. Гэхдээ тухайн ойлголтыг түүний анхны утганд нь нэгдмэлээр авч үзэх нь зорилгод нийцнэ. Хэл, газар нутаг, эдийн засгийн амьдрал ба соёлын нийтлэг нь адил байдалд илэрдэг сэтгэл зүйн ба эдийн засгийн амьдрал, хэл газар нутаг нь нэгэн адил зүйл дээр үндэслэж үүссэн ба түүхэн явцад бүрэлдэн тогтсон хүмүүсийн нийтлэг зүйл болох “орон”, “гүрэн” гэсэн үгнүүдтэй адил төстэй гэсэн тодорхойлолт өгч байна.

Хэвлэлийн тойм

Даяаршилын талаарх хэдийгээр XI зуунд багагүй ярьж бичиж байгаа ч түүнийг онолын түвшинд, шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судалсан судалгаа хангалттай сайн байгаагүй билээ. Харин сүүлийн 5 жилд ном зохиол, өгүүлэл илтгэлүүд хурдтайгаар гарсаар байгаа. Үүнд: В.Василенко “Политическая глобализация”, Н.Уткин “Глобализация и национальное сознание”, Мартин.Г.П., Х.Шуман “Западная глобализация”, 2.Панарин.А.С, “Искушение глобализмом”, Майкл.Д Интрилигейтор, “Глобализация как источник международных конфликтов и обострения конкуренции”, Международный журнал – Проблемы теории и практики управления, Globalization and change in Asia гэх мэт ололттой бүтээлүүд нэлээдгүй гарсаар байгаа. Харин бид энэхүү өгүүлэлдээ В.Василенко “Политическая глобализация”, Н.Уткин “Глобализация и национальное сознание”, Globalization and change in Asia ном зохиолуудыг түлхүү ашигласан болно.

Судалгааны материал, арга зүй

Уг илтгэлийг бичихдээ өрнө болон дорнын судлаачдын бичсэн ном, сурах бичиг, өгүүлэлүүдийг ашигласан болно. Уг илтгэлийг бичихдээ нийгмийн шинжлэх ухааны ерөнхий арга, түүхэн ба логик арга, харьцуулалтын арга,

загварчлах аргыг ашигласан бөгөөд олон ургальч үзлийн зарчим, бодитой хандах зарчмыг баримталсан болно.

Судалгааны үр дүн

Үндэстний гүрний тухай ойлголтын шинжлэх ухааны онцлогууд: Орчин үеийн шинжлэх ухаанд үндэстний гүрэн гэдэг (Францын *chat-nation*-гүрэн үндэстэн эсвэл Английн *nation-state*-үндэстэн гүрэн гэсэн утгатай) ойлголт нь түүхэн явцад бүрэлдэн бий болсон төвлөрсөн тусгаар тогтносон гүрнийг илэрхийлж байгаа онолын суурь бүлэг юм. (Франц, Итали, Герман, Испани гэх мэт) Ингэхлээр олон улсын харилцааны онолын тухайд үндэстний гүрнээс илүү их чухал ойлголт байхгүй, учир нь гүрэн үндэстний гүрэн гэдэг утгаараа гүрэнгүй олон улсын харьцаа байдаггүй болохоор “олон улсын” гэсэн бүх юмны үндсэн гишүүн юм. Судлаач нар нэгэн зэрэг гүрний оппортунист хэлбэрээр оршин тогтнодог шинжлэх ухааны тухайн байдлыг тайлбарладаг³⁸. Тухайн бүлэг ямар шинжлэх ухааны үнэ цэнэтэй вэ? Ер нь гүрнээс түүнийг тусгаарладаг үндэстний гүрний агуулга ба шинж тэмдгүүд нь ямар байх ёстой вэ? Манай оронд нийгмийн шинжлэх ухаанд 1990-ээд оны эхнээс үндэстэн гүрэн гэдэг үгийг идэвхтэй өргөн хэрэглэх болсон тэр үеэс тухайн ойлголтын агуулгын тухай болон түүнийг хаана хэрэглэх талаар маргаж эхэлсэн. Энэ маргаан нь эхний ээлжинд (юуны түрүүнд) философичид, түүхчид, улс төр судлаачид, хэлний мэргэжилтнүүд болон угсаатан судлаачдын анхаарлыг татсан. Тэр үеийн гүрэн үндэстэн гэсэн ойлголт нь Оросын эрх судлалд өргөн хэрэглэгдэж чадаагүй. Тийм үгийг хэрэглэсэн нь онолын талаас ч амьдрал дээр хэрэглэгдэх талаасаа ч нэлээд сонирхолтой ашигтай судалгааны давхаргаас манай орны хуулийн шинжлэх ухааныг салгахад хүргэсэн. Манай улсын онол дахь үндэстний гүрний онолын салбар дахь онолыг бараг тэгээс эхлэх хэрэгтэй болж байна. Учир нь марксист-ленинист онолд хэрвээ үзэл суртлын хэв маягийг тооцохгүй л юм бол энэ асуудлыг үнэн хэрэгтээ хайхардаггүй байсан гэж Н.Н.Деев тэмдэглэжээ³⁹. Мөн хуулийн шинжлэх ухаан нь үндэстний гүрэн гэж нэрлэгддэг бүсийн тусгаар тогтнолын үйл явцын урьдчилсан нөхцөл болсон жинхэнэ үндэстний гүрний зааг хязгаарт тусгай засаг захиргаа-нутаг дэвсгэрийн үүслийн оршин тогтнох эрхийн санаархлын онолын үүднээс үндэслэн, судалж байгаа цөөнгүй номыг гаргасан. Иймэрхүү судалгаануудыг үндэстний гүрнийг хэвлэлийн эрх мэдлийн өвөрмөц хэлбэрийн хувьд үүнийг судлах талаар ажлуудад хатуу оруулж болохгүй. Учир нь тэдгээрийг зохиогчдын “үндэстэн” гэсэн ойлголтонд оруулж байгаа утга нь олон улсын улс төр эрхийн шинжлэх ухаан дахь нийтээрээ хүлээн зөвшөөрсөн утгатай тохирохгүй байгаа төдийгүй анхны утгатайгаа тохирохгүй байгааг, мөн олон улсын эрхийн нэлээдгүй нэр томъёог буруу орчуулсныг зарим судлаачид нэг бус удаа тэмдэглэж байсан. Мөн үгийн гарлын уламжлалд тохирохгүй байгаа төдийгүй зөвхөн угсаатны зүйн утга руу оруулж, ингэснээрээ түүний утгыг явцууруулж байна. Эдгээр хандлага концепц тодорхой үе шатанд тусгаар

³⁸ “Политическая наука” орч. М.М.Гурвица, А.Л.Демчука, Т.В.Якушевой. ред Е.Б.Шестопап, М., 1999, 389х

³⁹ Деев.Н.Н “Государственность и этнополитическое развитие” М., 1993, 20-22х

тогтнолын жагсаал, үндэсний хөдөлгөөний гэж нэрлэгддэг зүйлс нь онолын үндэс нь болсон ба угсаатны хооронд мөргөлдөөн эвдрэлийг асаах ба нэлээд олон гүрний улс төр задрахад нэрмээс болсон. Үнэндээ тэдгээр нь бидний бодлоор улс төрийн дэглэмийн тоталитар хэлбэрийн төрөлд хамрагддаг этнократи легимагици ба үндэстэн болгоход чиглэгдсэн бөгөөд туйлын илрэл нь фашизм болсон. Харин хамгийн аюултай гэмт хэрэг нь геноцид бөгөөд улс гүрэн сүйрч мөхөхийн шинж тэмдэг болдог.

Үндэстнийг ойлгох. “Үндэстэн гүрэн” гэдэг ойлголт нь өөрийнхөө агуулга багтаамжаараа болон хэрэглэгдэх индексээрээ “ардчилал”, “иргэний нийгэм” ба “хүний эрх” зэрэг ойлголтуудаас дутахгүй. Үндэстний гүрний тухай шинжлэх ухааны товч тодорхойлолтыг гаргахынхаа өмнө тухайн ойлголтын үгийн сангийн үндсэн хэсгийг бүрдүүлэгч “үндэстэн” ба “гүрэн” гэсэн үгнүүдийг авч үзэхийг оролдлоо. Гэхдээ тухайн ойлголтыг түүний анхны утганд нь нэгдмэлээр авч үзэх нь зорилгод нийцнэ. Хэл, газар нутаг, эдийн засгийн амьдрал ба соёлын нийтлэг нь адил байдалд илэрдэг сэтгэл зүйн ба эдийн засгийн амьдрал, хэл газар нутаг нь нэгэн адил зүйл дээр үндэслэж үүссэн ба түүхэн явцад бүрэлдэн тогтсон хүмүүсийн нийтлэг зүйл болох “орон”, “гүрэн” гэсэн үгнүүдтэй адил төстэй гэсэн тодорхойлолт өгч байна⁴⁰. “Үндэстэн” бол төвийг сахихийн хамт өөрсдийгөө нэгдмэл буюу нэг бүлэг гэж үздэг хүмүүсийн бүлэг юм. Үндэстэнд голдуу дараах онцлог шинжүүдийн нэг буюу нэлээд хэдэн шинжтэй байдаг. Үүнд: хэл, соёл, шашин, улс төрийн ба бусад ёс журам, хууль, түүх гэх мэт шинжүүд багтан ордог. Үндэстнүүд гол төлөв чигжүү газар нутгийг эзлэн байдаг гэж “Americana”-д мэдээлжээ⁴¹. “Үндэстэн” гэдэг үгийн утга ийм тодорхой бус байгаа энэ үгний анхан шатны тайлбарыг буруу хийгээд зогсохгүй цаашид үндэстэн гүрэн гэсэн чухал зүйлийг буруу ойлгох, гажуудуулахад хүргэж байна.

Үндэстнийг ойлгох хандлагууд. Энэ талаар үндэстэн гэдэг ойлголтыг судлаачид мөн хүн амын ихэнх нь буруугаар хүлээн авдаг. Энэ нь явцуу хэсгийн буюу улс төрийн зорилгыг хамгаалдаг үзэл суртлын удирдамжийн олон жилийн турш давуу эрхтэй байсантай холбоотой (Үндэстний тухай марксист-ленинист ойлголтыг шүүмжилсэн цөөнгүй бүтээл байдаг)⁴². Үнэхээр энэ ойлголтыг ойлгоход тийм ч илэрхий маргашгүй биш бөгөөд болхи байдаг билээ. Энэ талаарх шинжлэх ухааны ойлголт олон зууны турш зөрчилтэй, маргаантай байсан бололтой байдаг. Зөвхөн үндэстэн гэдэг ойлголт нь өөрчлөгдөөд зогсоогүй nation гэдэг латин үгний үг зүйн утга нь хүртэл өөрчлөгджээ. (“төрөх” гэсэн үйл үгнээс “аймаг”, “давхрага”, “байдал” гэдэг гэдэг нэр үгүүд өөрчлөгдсөн). Хэлний ялгааны тухай бол ярилт ч үгүй. Гадаад дотоодын нэр хүндтэй мэргэжилтнүүдийн боловсруулсан онол дээр тулгуурлан “үндэстэн” гэдэг ойлголтонд хандах үзлийн үндсэн хэдэн үзлийг ялган авъя. Үндэстний судалгааны онолын гол чиглэлийн ба давамгайлах үзэл бодлыг үндэслэгчид ба дэлхийн тэргүүлэх судлаачид бол Андерсон, Э.Геллнер, К.Дейч, А.Смит,

⁴⁰ “Современный словарь иностранных слов”, М.,1999, 320х

⁴¹ “The Encyclopedia Americana”, 1994.Vol.19.P.751 752

⁴² Торукало.В.П.,“Нация:история и современность”, М.,1996.

Э.Хобсбаум нар юм. Үндэстний онолын тухай түүх зүйд С.А.Арутюнов, Ю.В.Бромлей, Л.М.Дробижева, В.В.Корожеева, В.А.Тишков нар их хувь нэмрээ оруулсан⁴³. Тухайн чухал үзэгдлийн ойлголтонд хандах хандлагыг уламжлал ёсоор дараах хандлагуудад хуваадаг.

1. Англи үзлийн хүрээнд үндэстэн ба угсаатан гэж хуваадаг ба тэгэхдээ үндэстэн гэдгийг нийгмийн соёл нэгтэй, иргэншил нэгтэй угсаатан гэж ойлгож байна⁴⁴.

2. Германы уламжлалын чиглэлд (мөн түүнчлэн төв болон дорнод европын орнуудад) үндэстнийг угсаатны тодорхой хэлбэр мэтээр авч үздэг. Тийм үзэл бодлыг А.Г.Абдула-типов, Т.Ю.Бурмистрова, М.С.Джунусов, Л.М.Драбижева, В.Торукола нар гаргаж ирж байна⁴⁵.

3. Үндэстэн ба угсаатныг адилтган үзэх нь үзэл суртал ба нийгэм, улс төрийн зохиол бүтээлд байдаг онцлогтой болохоос биш нухацтай эрдэм шинжилгээний судалгаанд байдаггүй.

В.Махначийн үзэж байгаагаар тэдгээрийг адилтгах явдал Ази, Африкийн орнуудад ч тааралддаг. Эдгээр орнуудад үндэстэн гүрний талаарх барууны томъёолол хэрэглэгдэж байгаа бус харин угсаатны суурин дээр салгах үзлийн хөдөлгөөний онолын үндэс болон ашиглагдаж байна. Эхний 2 хандлагын хоорондын ялгаа нь үндэстний байгуулалын үйл явцын эцсийн зорилгыг ойлгох онцлогт оршдог. Үүнд: Францын үндэстний тухай ойлголт нь ижилсүүлэхэд чиглэгддэг, харин Германых нь ялгахад чиглэгддэг. Энэ тохиолдолд угсаатны соёлын ялгааг нь нийгмийн талаас зохион байгуулах хэлбэр мэтээр авч үздэг.

Тэгвэл В.А.Тишковым “Үндэстэн хэмээх ойлголт нь оршин тогтнох эрхгүй бөгөөд шинжлэх ухааны хэлнээс хасагдах ёстой гэсэн байр суурийг санахгүй байж болохгүй. Тийм алхам нь “улс төрийн уриа”, “дайн байлдааны” болон улс төрийн өрсөлдөөний хэрэгслийн шинжтэй юм⁴⁶. Өөрөөр хэлбэл угсаатны бүлэгтэй үндэстний тухай ойлголтыг адилтган авч үздэг маш олон хүний ойлголтыг шинжлэх ухаан өөрчлөх боломжгүйгээс урган гарсан бизээ.

Үндэстэн, угсаатны тухай: Тухайн газар нутаг дээр түүхийн явцад бүрэлдэн тогтсон зөвхөн ерөнхий шинж байдлаараа төдийгүй бас соёлын болон сэтгэл зүйн харьцангуй тогтвортой онцлогт шинжүүдтэй (хэлийг оролцуулан), мөн түүнчлэн угсаатан гэж өөрсдийгөө нэрлэдэг бусад бүх төстэй байгууллагаас ялгаатай бөгөөд нэгдмэл гэдгээ ухамсарласан тогтвортой үе үеийн хоорондох бүлэг хүмүүсийг бид угсаатан гэж ойлгох болно⁴⁷. Янз бүрийн тооцоогоор дэлхий дээр 3-4 мянган угсаатан байгаа нь тооны хувьд өөртөө шингээж, нийгмийн соёлын зохион байгуулалтын нэлээд эртний хэлбэрийг хэлэх бөгөөд

⁴³ Коротева.В.В, “Теории национализма в зарубежных науках” М., 1999.

⁴⁴ “Национальное государство: теория, история, политическая практика” Полис. 1992. 9,25х

⁴⁵ Торукало.В.П. “Нация: история и современность” М.,1996. 52х

⁴⁶ Тишков.В.А. “О нация и национализме” Свободная мысль. 1996. №3, 35х

⁴⁷ Бромлей.Ю.В “Этнос и политика” (Хрестоматия), М.,2000, 20х

түүний дотор төстэй төрх болон шууд хувийн харилцан холбоотой байдал дээр үндэслэгдсэн овгийн холбоог нийлүүлж хуримтлуулан нэгтгэсэн гүрэн ба үндэстний бүх талын давуу талыг арифметикийн хувьд баталж байна. В.М.Межуевийн тэмдэглэснээр: угсаатан гэдэг бол миний дотор биш харин гадуур оршиж байгаа, намайг төрсний баримтаар авсан биш харин өөрийн хүчин чармайлт болон хувийн сонголтоороо авсан тэр зүйл бөгөөд үндэстний шинж тэмдэг нь хувь хүний тэмдэгийн эсвэл билэг тэмдэгийн, гадаад шинж тэмдэгтэй байдгаараа үндэстэн угсаатнаас ялгаатай. Түүний ойлголтоор үндэстэн гэдэг бол хувь хүний, төрийн, нийгмийн, соёлын харъяалал болохоос биш түүний хүн судлалын, угсаатны судлалын талын тодорхой байдал биш юм⁴⁸. В.Л.Торукало үндэстний тухай дараах үндсэн тодорхойлолтуудыг онцлон гаргаж байна. Ингэхдээ үндэстнийг субъектив-сэтгэл зүйн мөн чанар, хүмүүсийн соёлын нэгдмэл байдал, төрийн үүсэл, соёл иргэншил, газар зүйн мөн чанар, биологи нийгмийн нэгдэл, улс төржүүлсэн угсаатан зүй буюу тэр ч байтугай улс төрийн зохион байгуулалт, нутаг дэвсгэрийн үүсэл, харьцангуй түүхэн буюу түүхэн үүрэгтэй категори юм⁴⁹.

Утгын хувьд ийм олон хувилбартай байгаа нөхцөлд үндэстний талаарх шинжлэх ухааны нэг төрлийн тодорхойлолт ярихад хэцүү юм. Ийм учраас энэ судалгааны зорилгод илүү тохирсон үндэстний шинжүүдийг ялган авахыг оролдоё. Капиталист үйлдвэрлэл дээр суурилсан аж ахуйн харьцааны нэгдмэл байдал, нутаг дэвсгэр, хэл, соёл нэгтэй мөн түүнчлэн үндэстний өөрийн ухамсар гэх мэт. Үндэстэн бол орчин үеийн түүхэн дэх хүн амын угсаатны, нийгэм, соёлын болон улс төрийн нэгдлийн хамгийн дээд хэлбэр юм. Юу бүлэг хүмүүсийг үндэстэн болгодог вэ гэсэн асуултанд Э.Ренан хариулахдаа: хэрвээ дэлхий дээрх үндэстнүүд нэгдэхэд бэлэн байгаагаа илэрхийлэхэд улс төрийн тохиолдол байхгүй бол энэ байгаа бүх үндэстний шинж тэмдэг утгаа алдана гэж үзсэн байна⁵⁰. Түүнийхээр үндэстэн бол их чухал асуудлаар төрөөс явуулж байгаа бүх ард түмний саналын тусламжтайгаар өдөр бүр шалгуурт орж байдаг нэг эрмэлзэл ба мэдрэмжээрээ нэгдсэн хүмүүсийн хамтарсан нийгэмлэг өөрөөр хэлбэл энэ хамтарсан нийгэмлэг нь (үндэстэн) байнга дахин дахин өөрийгөө оршин байгааг баталж байх ёстой юм байна. Чухамдаа хувь заяагаа ухамсарлах, цаашид улс төрийн нэгдэлд байхад бэлэн байгаа нь үндэстнийг хүн төрөлхтнөөс нэлээд эртний нэгдлээс ялгаатай болгож байсан байна

Үндэстэн угсаатан ба ард түмний хоорондын харьцаа: Онолын нэлээд чухал өөр нэг асуудал бол “үндэстэн”, “ард түмэн” ба “угсаатан” гэсэн категориудын харьцаа юм. Мөн түүнчлэн энэ гурвалсан дүн шинжилгээний элемент бүрийн эрхийн утга учрыг олох нь ч бас нэг чухал асуудал юм. Дээр заасан ойлголтуудын хоорондын бүх ялгааг тодорхой тогтоох нь 1. хуулийн тодорхой тохиолдол, нөхцөл байдлыг тодорхойлох аргуудыг дэс дараатайгаар

⁴⁸ Межуев.В.М “Национальное государство: теория, история, политическая практика”, Полис. 1992, 16х

⁴⁹ Торукало.В.П.,”Нация:история и современность” М.,1996, 51х

⁵⁰ Торукало.В.П.,”Нация:история и современность” М.,1996, 105х

бий болгоход, 2. мөн эх орны хуулийн техник дэх сөрөг үзэгдлээс хамгаалахад зарчмын ач холбогдолтой. (Жишээ нь: улс гүрэнд өөрийгөө тодорхойлж амжаагүй байгаа үндэстнүүд байдгийг батлах үндэслэл бий болгодог “олон үндэстэнтэй ард түмэн” гэх мэтийн буруу шинжлэх ухааны томъёолууд). Иймэрхүү онолын будлианы шалтгааны нэг нь нэг талаас: энэ ойлголтыг нэг шинжлэх ухаанаас нөгөөд оруулж ирсэн үйл явц бөгөөд түүнтэй уялдаатай шинэ үеийн дасан зохицох зарчмын ээдрээтэй үйл явц байна. (Философи, социологи, антропологи зэрэгт нөлөөлдөг), Нөгөө талаас нэг гол санаа нь бүлгийн аппаратын экстрарополяцийг арай илүү өргөн зүйлийг тэдгээрийн бодит дүрслэл дээр бичих боломжтой байдгийг харгалзахгүйгээр шилжүүлж байна. (Жишээ нь: ардчилал ба тусгаар тогтнолын ялгаа).

Төр ба эрхийн онолд “үндэстэн” гэдэг ойлголтыг хэрэглэхийг эсэргүүцэгч нэртэй хүмүүсийн дунд Л.С.Мамут байдаг ба тэрээр зөвхөн төрийг үүсгэх үндэслэлийн үүрэгтэй “ард түмэн” гэдэг категорин дор л хуулийн тухайн байдлыг хүлээн зөвшөөрдөг⁵¹. Үүний зэрэгцээ эдгээр 3 үзэгдэл нь янз бүрийн улс төр, эрх зүй, нийгэм-соёл, сэтгэл зүйн онолын гол санаа нь болсон билээ.

Үндэстэн ба ард түмэн гэсэн 2 үгийг зааглан тогтооход тусгаар тогтнолын гол тусгаар тогтнолын тухай гол санааны үүрэг: Өмнөх нийгмийн систем нуран унасны дараа “ард түмэн” гэдэг ойлголт нь “хэмжээгүй эрхт хаант” улсын удирдагч гэсэн үгийн эсрэг гэсэн утгатай, засгийн эрх ээлжлэн солигдох хууль эрхийн эх үүсвэр гэсэн утга санааг заах болсон. Тусгаар тогтнол нь бүх ард түмний засгийн эрх ба төрийн нэг төрлийн эрхийн үндэслэл нь болдог. “Ард түмэн” гэдэг үгийн ийм ойлголт нь гэгээрлийн үе, ардын тусгаар тогтнолын үед үндэс нь тавигдсан. Ийм учраас түүнийг “ардчилал”, “ардын засаг” ба бүгд найрамдах улс (ардын үйл хэрэг гэсэн нэг язгууртай үгнүүдтэй нэг эгнээнд авч үзвэл зохино) гэсэн утгаар хэрэглэх болсон. Авч үзэж байгаа ойлголтуудын хоорондох анхны ялгаа нь үндэстэн бол чанарын хувьд нийгмийн хөгжлийн шинэ хэлбэр, үзэл суртлын үзэгдэл ба нийгмийн интеграцийн илүү их утга агуулсан бүтэц юм. Энд түүхийн хөгжлийн орчин үеийн үе шатанд иргэний хариуцлага болон иргэний эв нэгдэл дээд зэргээр илэрдэг. Ингэхлээр ард түмэн нь үндэстэн гэдэг үгийн түүхийн урьдач нөхцөл бөгөөд үндэстэн нь нэлээд хожуу үеийн илүү боловсорсон бүрдэл юм. Энэ талыг К.Дейч, Б.Г.Капустин, В.И.Фрейдзон нар баримталдаг. Тухайн тохиолдолд үндэстэн гэдэг нь “нийгмийн зарим институтэд албадлагын хяналт тавих болсон ба бүрэн эрхт үндэстний төр болж үүсч чадах хэтийн төлөвтэй юм. Тэр нь ард түмний төрийн хөгжлийн бүтээгдэхүүн юм⁵². Эл үзэл санааг П.И.Симуш баримталдаг ба ард түмнээс гаднах зүйлийг (организм) олж харж байгаа бөгөөд тэр нь угсаатан ба ард түмэнд байдаг угсаатны ба хууль эрхийн талаасаа юуны өмнө улс төрийн бүрэлдэхүүнээрээ ялгагддаг байна⁵³. Ард түмэн үндэстэн угсаатан болж хувирах үйл явц нь Гегелийн диалектикийн хуулиар явагддаг байна. Гэхдээ

⁵¹ Мамут.Л.С “Народ в правовом государстве” М.,1999. 27х

⁵² Дейч.К Рост наций “Этнос и политика: Хрестоматия” М.,2000. 63х

⁵³ Симуш.П.И “Как раскрывается код российского народа” Власть. 2000 №1, 67х

үүнтэй холбоотойгоор ард түмний үүргийг эерэг талаас нь туйлшруулахыг зөвшөөрч болохгүй. Учир нь ард түмэн бол төртэй холбоотой ба төрийн хуулинд захирагддаг нэгдсэн хүмүүсийн нийлбэр юм.

Ард түмэн гэдгийг хүн амаас ялгах хэрэгтэй. Хүн ам - нийгэм, хүн амны үзэгдэл ард түмэн - хууль эрхийн үзэгдэл, үндэстэн-улс төрийн үзэгдэл, угсаатан–нийгэм, соёл, хүн амны хөгжлийн бүтээгдэхүүн байдаг⁵⁴. Энд ард түмэн нь улс төрийн дээд дэргийн идэвхтэй байхаас гадна төрийн хэрэгт оролцогч, идэвхтэй сонгох ба сонгогдох эрхтэй иргэдийн төв байр нь болж гарч ирдэг. Гэвч өмнөх нийгмийн оршин тогтнол нь ул мөргүй алга болохгүй харин эсрэгээр түүний шинж тэмдгүүд нь цаашид үргэлжлэн илэрч гарсаар байдаг. Зөвхөн үүрэг нь солигдон, хөгжлийн илүү өндөр түвшин рүү шилждэг.

Үндэстэн ба ард түмэн гэсэн ойлголтуудыг ялган салгахад зөвхөн тусгаар тогтнолын зарчим төдийгүй бас ардчиллын онол, газар нутаг, үндэстний ашиг сонирхол ба үндэстний адилсал чухал ач холбогдолтой. Үндэстэн үүсэх үйл явцад ард түмэн чухал үүрэгтэй гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой. Нэг талаас ардчиллыг бий болгох, түүнийг тогтвортой болгохын тулд өөрсдийгөө нэг нэгдмэл зүйл гэдгээ ухамсарласан ард түмэн оршин тогтносон байх ёстой. Нөгөө талаас зүгээр нэг угсаатан биш үндэстэн гэж бидний ойлгоод байгаа тэр зүйлийг бий болгохын тулд ардчилсан ухамсар, нэг бүхэллэг зүйлийн нэг хэсэг буюу хувь гэж өөрийгөө ухамсарласан иргэн бий болсон байх шаардлагатай. Ард түмэн, үндэстэн хоёрын хооронд тасралтгүй холбож байгаа нэг салаа нь ардчилал юм гэж үздэг Т.А.Алексеевичийн үзэл бодлыг хүлээн зөвшөөрч байна. Т.А.Алексеевич, А.А.Гусейнов нар үндэстэн гэдэг нь (категорийнхоо хувьд) хоорондоо харилцан нөхцөлдсөн байдаг ардчилсан ба эрх зүйт төр үүсэхтэй холбоотой гэж үзсэн байдаг. Гэвч ард түмэн нь хэдийгээр зайлшгүй байх ёстой ч зөвхөн үндэстэн үүсэхэд төдийгүй төр бий болоход ч хангалттай нөхцөл нь болж чаддаггүй. Түүхийн ихэнх үед ард түмэн гэдэг зүйл илрэн гарч байхад үндэстний үзэл ба үндэстэн гэдэг зүйл хамаагүй ховор тохиолдож байсан байна. Үндэстэн нь нийгмийн үйл явцад хэд хэдэн угсаатны элементүүд ард түмэн гэдэг үгэнд шилжин орсоны үр дүн юм. Ю.В.Бромлейгийн үзлээр “Ард түмэн” гэдэг ойлголт нь нэг угсаатан хүмүүсийг заадаг боловч зөвхөн нэг улсын газар нутаг дээр оршиж байгаа хүмүүсийг ч хамаардаг. Бидний хувьд ч санал болгож байгаа онолын схемээс авч үзэхэд “үндэстнийг тодорхой улсгүйгээр төсөөлөх аргагүй ба үндэстэн нь улс дотроо бий болдог байна. Улс нь тухайн нийгэм-улс төрийн мөн чанарын хувьд өвөрмөц тогтсон ёс заншлын нөөцлүүр юм.

Орчин үед угсаатан, ард түмэн, үндэстний талаар ийм маягийн тодорхойлолтууд нь улам л арчигдсаар л байгаа. Харин эдгээрийн зарим нь эргэлзээтэй болоод байна. Ю.Арутюнян үндэстнийг ойлгох өөрийн орны уламжлалд дүгнэлт өгөхдөө В.А.Тишковым үндэстний тухай ойлголтыг угсаатны гэсэн агуулгаас нь биш харин иргэний талаас нь дахин авч үзэх тухай саналыг

⁵⁴ Мамут.Л.С “Народ в правовом государстве” М.,1999. 27х

“урьдын ерөнхий төсөөллийн бүтцээ стратегийн талаар сольж байгаа” гэж үзэж байна⁵⁵. Олон улсын хэд хэдэн баримт бичигт шинжилгээ хийсний дараа “үндэстэн” гэдэг ойлголтыг улс төрийн, иргэний ба тухайлбал, НҮБ-д хэрхэн хэрэглэснийг харж болно.

Дүгнэлт

Үндэстэн ба угсаатан, ард түмэн гэсэн ойлголтын тухай нэр томъёоны хувьд чамгүй ээдрээтэй будлиантай асуудал болоод байгаа билээ. Энэ талаарх шинжлэх ухааны ойлголт олон зууны турш зөрчилтэй, маргаантай байсан бололтой байдаг. Зөвхөн үндэстэн гэдэг ойлголт нь өөрчлөгдөөд зогсоогүй nation гэдэг латин үгний үг зүйн утга нь хүртэл өөрчлөгдсөн байна. Утгын хувьд ийм олон хувилбартай байгаа нөхцөлд үндэстний талаарх шинжлэх ухааны нэг төрлийн тодорхойлолт ярихад хэцүү. Мөн үгийн гарлын уламжлалд тохирохгүй байгаа төдийгүй зөвхөн угсаатны зүйн утга руу оруулж, ингэснээрээ түүний утгыг явцууруулж байна. Үндэстэн бол орчин үеийн түүхэн дэх хүн амын угсаатны, нийгэм, соёлын болон улс төрийн нэгдлийн хамгийн дээд хэлбэр юм. Тэгэхээр юу бүлэг хүмүүсийг үндэстэн болгодог вэ? гэсэн асуудалд: дэлхий дээрх үндэстнүүд нэгдэхэд бэлэн байгаага илэрхийлэхэд улс төрийн тохиолдол байхгүй бол энэ байгаа бүх үндэстний шинж тэмдэг утгаа алдана гэж ихэнх эрдэмтэд үзсэн байна. Өөрөөр хэлбэл, үндэстэн бол их чухал асуудлаар төрөөс явуулж байгаа бүх ард түмний саналын тусламжтайгаар өдөр бүр шалгуурт орж байдаг нэг эрмэлзэл ба мэдрэмжээрээ нэгдсэн хүмүүсийн хамтарсан нийгэмлэг өөрөөр хэлбэл энэ хамтарсан нийгэмлэг нь (үндэстэн) байнга дахин дахин өөрийгөө оршин байгааг баталж байх ёстой юм байна. Чухамдаа энэ нь хувь заяагаа ухамсарлах, цаашид улс төрийн нэгдэлд байхад бэлэн байгаа нь үндэстнийг хүн төрөлхтнөөс нэлээд эртнээс ялгаатай болгож байсан байна.

Ном зүй

1. А.Блинов.”Национальное государство в условиях глобализация,М.,2003
2. Арутюнян.Ю.В, Дробижеева.Л.М, Сусоколов.А.А “Этносоциология” Сурах бичиг, М.,1999,
3. Аристотель “Политика”,М.,1997
4. Бородай.Ю.М.”Этнос, нация, государство” М.,1992
5. Бромлей.Ю.В.”Этнос и политика”(Хрестоматия), М.,2000,
6. Деев.Н.Н “Государственность и этнополитическое развитие” М.,1993,
7. Дейч.К Рост наций “Этнос и политика:Хрестоматия” М.,2000.
8. Коротеева.В.В, “Теории национализма в зарубежных науках” М.,1999.
- 9.“Национальное государство: теория, история, политическая практика” Полис.1992.
10. Межуев.В.М“Национальное государство: теория, история, политическая

⁵⁵ Арутюнян.Ю.В, Дробижеева.Л.М, Сусоколов.А.А “Этносоциология” Сурах бичиг, М.,1999, бүлэг 2

11. Мамут.Л.С “Народ в правовом государстве” М.,1999.
- 12.“Политическая наука” орч.М.М.Гурвица, А.Л.Демчука, Т.В.Якушевой. ред Е.Б.Шестопал, М.,1999,
13. “Современный словарь иностранных слов”, М.,1999,
14. Торукало.В.П,”Нация:история и современность”, М.,1996.
15. Тишков.В.А. “О нация и национализме” Свободная мысль.1996.13
16. Симуш.П.И “Как раскрывается код российского народа” Власть.2000
17. “The Encyclopedia Americana”, 1994.Vol.19.

Резюме

Под национальным государством понимается сформировавшаяся в индустриальную эпоху политическая организация общества, легитимность которой обеспечивается представлением и защитой интересов, включенных в нее индивидов на основе идей и ценностей социокультурной, духовной, исторической, языковой, территориальной сплоченности и единого уровня экономического развития. Национальное государство, представляющее собой исторический тип организации публичной власти, является переходным этапом в развитии государственности и предшествует появлению более универсальных, масштабных в пространственно-территориальном и демографическом плане социальных союзов с более высокой степенью внутренней однородности и интегрированности всех членов. Термин “государство” по объему и содержанию значительно уже “государственности”, под которой понимается состояние и опыт публичной самоорганизации общества на разных этапах его исторического развития, обусловленные экономическими, социокультурными, духовными условиями жизнедеятельности представляющего его народа и реализованные в системе институтов, практике политического управления. Нация, национальная идентичность и интересы стали универсальными легитимирующими основаниями верховной власти и современного государства, эмпирическим условием политической лояльности и активности граждан.